



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨГҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтэс,
Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн үйл ажиллагааны
үндсэн чиг үүргийг батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” А/121 тоот захирамж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтэс, Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хавсралтаар баталсугай.

2.Чиг үүрэг батлагдсантай холбогдуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Б.Алтан-Очир/, Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер /Г.Пүрэвдорж/-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /А.Нямхүү/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ

3150600039